



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙД Х.БУЛГАНТУЯА ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2024.04.15 № 09

Асуулт тавих тухай

Сүүлийн үед хүүхдийг хүчирхийлсэн гэх үйлдэл удаа дараа гарсан талаар эрх бүхий байгууллагаас тухай бүр мэдээлэл хийж ирсэн.

Сүүлийн 10 жилийн байдлаар жилд дунджаар 1468 хүүхэд гэмт хэргийн улмаас хохирсон байна. Гэмт хэргийн улмаас хохирсон 1365 хүүхдийн 38 (2.8%) нь Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч, 362 (26.5%) нь Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч, 293 (21.5%) нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хохирогч, 471 (34.5%) нь Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч, 156 (11.4%) нь Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам /ХАБТХАЖ/ -ын эсрэг гэмт хэргийн хохирогч болсон байна. Мөн Прокурорын байгууллагын мэдээгээр 2023 онд 3606 хүүхэд гэмт хэргийн улмаас хохирсон байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн энэхүү асуултыг Танд тавьж байна. Үүнд:

1. Хүүхэд хамгааллын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт, хүүхдийн эрхийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа бодлого, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар;
2. Хүүхдийн эрх хамгаалах чиг үүрэг бүхий албан тушаалтнаас хүүхдийн эсрэг гаргасан хэрэг, зөрчлийн шийдвэрлэлтийн талаар, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар;
3. Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний талаар;
4. Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар;
5. Хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар;
6. Хүүхдэд ээлтэй орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар;
7. Цаашид хүүхдийн хүчирхийллийг бууруулах чиглэлээр төлөвлөсөн арга хэмжээний талаарх мэдээлэл.

Дээрх асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасны дагуу ирүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Д.ӨНӨРБОЛОР



2024.04.15